

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/071-НА-СТА-ТӨА

ТӨВ АЙМГИЙН ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ ОНӨААТҮГ-ИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага	166
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	17
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	17
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
ЗТХЯ	Зам тээвэр Хөгжлийн Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2024
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ТӨВ ЧАНДМАНЬ
ДЭХГ-ЫН ЗАХИРАЛ Ц.БАТСҮХ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардал, Бүрэн сумын халаалтын зуухны зардал, СӨХ-ийн зардал, удирдлага борлуулалтын зардал, үндсэн үйл ажиллагааны бус зардлыг нийт 582,022.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 15-р хуралдааны 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 11 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 3-н удаагийн захирамжаар 3, 10-р зууханд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3ш тогоог 1,600,000.0 мянган төгрөгөөр БНХАУ-аас худалдан авч техник шинэчлэлт хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж

GI/Arkhiv/Alban_bichig_2024/A4

авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	18,643,356,854.36	20,783,272,961.98
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,078,307,266.05	1,514,105,390.20
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	43,167,444.06	102,655,697.21
1.1.2	Дансны авлага	664,847,300.28	720,858,189.09
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	31,671,934.27	45,507,383.86
1.1.4	Бусад авлага	-	66,818,867.38
1.1.6	Бараа материал	306,262,101.92	518,466,721.48
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	32,358,485.52	59,798,531.18
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,078,307,266.05	1,514,105,390.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	17,565,049,588.31	19,269,167,571.78
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,962,517,010.41	16,672,107,559.33
1.2.2	Биет бус хөрөнгө	1,473,095,663.90	1,467,623,098.45
1.2.3	Биологийн хөрөнгө	5,590,000.00	5,590,000.00
1.2.9	Дуусаагүй барилга	1,123,846,914.00	1,123,846,914.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,565,049,588.31	19,269,167,571.78
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,643,356,854.36	20,783,272,961.98
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	18,643,356,854.36	20,783,272,961.98
2.1	ӨР ТӨЛБӨР	1,320,625,554.59	2,735,381,876.37
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	1,311,664,584.64	2,730,920,906.42
2.1.1.1	Дансны өглөг	859,167,970.44	1,890,884,110.70
2.1.1.3	Татварын өр	348,900,531.27	257,546,863.13
2.1.1.4	НДШ-ийн өглөг	47,645,356.68	462,753,481.89
2.1.1.5	Богино хугацаат зээл	30,240,000.00	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,860,708.85	85,003,091.30
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	21,850,017.40	34,733,359.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,311,664,584.64	2,730,920,906.42
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	8,960,969.95	4,460,969.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,960,969.95	4,460,969.95
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,320,625,554.59	2,735,381,876.37
2.3	Эздийн өмч	9,377,964,826.06	11,322,083,327.24
2.3.1	Төрийн өмч	7,016,820,599.85	7,016,820,599.85
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний өмчлөлийн өмч	2,023,477,561.76	2,018,581,093.41
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,377,964,826.06	11,322,083,327.24
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,095,531,687.90)	(2,309,593,934.89)
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,322,731,299.77	18,047,891,085.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	18,643,356,854.36	20,783,272,961.98

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайланг жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,847,907,404.78	10,332,143,908.74
2	Борлуулалтын өртөг	-9,038,778,695.49	-11,310,464,929.86
3	Нийт ашиг (алдагдал)	-190,871,290.71	-978,321,021.12
5	Хүүгийн орлого	0.00	402,721.88
8	Бусад орлого	121,464,723.36	1,698,896,437.71
9	Борлуулалт, маркетингийн зардал	124,641,344.21	149,411,844.35
10	Ерөнхий ба удирдлагын зардал	86,002,839.36	89,866,021.87
12	Бусад зардал	128,830,038.87	1,697,218,219.24
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-408,880,789.79	-1,215,517,946.99
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-408,880,789.79	-1,215,517,946.99
22	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-408,880,789.79	-1,215,517,946.99

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,016,820,599.85	4,050,282,340.97	5,787,946,885.53	-686,650,899.11	16,168,398,927.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	7,016,820,599.85	2,684,972,734.77	7,153,256,491.73	-686,650,899.11	16,168,398,927.24
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	3,616,525.00	2,704,761,770.86	0.00	2,708,378,295.86
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00		-480,053,436.53	0.00	-480,053,436.53
6	Зарласан ногдол ашиг	0.00		0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-408,890,788.79	-408,890,788.79
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	-665,111,698.01	0.00	0.00	-665,111,698.01
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,016,820,599.85	2,023,477,561.76	9,377,964,826.06	-1,095,531,687.90	17,322,731,299.77
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	7,016,820,599.85	2,023,477,561.76	9,377,964,826.06	-1,095,531,687.90	17,322,731,299.77
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	2,561,900,994.00	0.00	2,561,900,994.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	-617,782,492.82	1,455,700.00	-616,326,792.82
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-1,215,517,946.99	-1,215,517,946.99
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	-4,896,468.35	0.00	0.00	-4,896,468.35
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,016,820,599.85	2,018,581,093.41	11,322,083,327.24	-2,309,593,934.89	18,047,891,085.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үе
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,446,689,911.82	12,122,550,303.24
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	9,203,566,151.82	10,202,909,221.76
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	243,123,760.00	1,730,855,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	188,786,081.48
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,075,965,356.83	11,677,083,233.09
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,173,930,045.00	2,687,519,371.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	803,284,036.00	518,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,132,923,269.25	2,869,140,228.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	758,292,952.80	741,349,392.05
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,552,280,935.92	3,846,794,578.12
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	393,207.40
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	550,488,582.13	836,356,415.06
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,270,000.00	1,270,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	103,495,535.73	176,260,041.16
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	370,724,554.99	445,467,070.15
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,100,082.00	48,867,074.88
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	26,100,082.00	48,464,353.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	402,721.88
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	366,178,375.69	404,845,891.88
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшиж төлсөн	333,995,535.69	356,381,538.88
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	32,182,840.00	48,464,353.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-340,078,293.69	-355,978,817.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	30,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	30,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-30,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	30,646,261.30	59,488,253.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,521,182.76	43,167,444.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,167,444.06	102,655,697.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2022 он гүйцэтгэл	2023 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэл, хэмнэлт	Хувь
1	Орлого					
	Дулааны эрчим хүчний орлого	6,556,369.10	7,576,602.50	7,650,212.90	73,610.40	101%
	Цэвэр усны орлого	840,343.10	841,195.60	867,548.10	26,352.50	103%
	Ариутгах татуургын орлого	380,288.10	379,674.10	402,395.10	22,720.90	106%
	Ус түгээх байраар борлуулах цэвэр усны орлого	30,282.40	39,800.00	29,072.40	-10,727.60	73%
1.1	Орон сууцны засвар, дуудлагын орлого	9,984.80	9,984.80	20,532.40	10,547.60	206%
	Божир гэсгээлтийн орлого	4,659.90	4,659.90	6,303.70	1,643.90	135%
	Тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр бохир татан зайлуулах үйлчилгээний орлого	64,067.80	64,067.80	111,282.90	47,215.00	174%
	Үндсэн үйл ажиллагааны орлого	7,885,995.30	8,915,984.70	9,087,347.50	171,362.70	102%
1.2	Бусад үйл ажиллагааны орлого	763,336.10	1,166,942.40	1,113,941.50	-53,001.00	95%
1.3	Санхүүжилтийн орлого	224,284.50	150,692.20	130,855.00	-19,837.30	87%
	ҮҮА-ны нийт орлогын дүн	8,873,615.80	10,233,619.40	10,332,143.90	98,524.50	101%
1.4	Харилцахын үлдэгдэлд бодогдсон хүүний орлого	0	0	402.7	402.7	0%
1.5	Бусад орлогын дүн	95,756.30	55,522.40	1,698,896.40	1,643,374.10	3060%
	Нийт орлогын дүн	8,969,372.10	10,289,141.80	12,031,443.10	1,742,301.30	117%
2	Зардал	8,672,874.00	11,232,463.00	10,789,292.30	443,170.60	104%
3	ББӨртөг	8,980,621.40	11,767,339.90	11,282,128.40	485,211.50	104%
4	Нийт өртөг	9,003,187.70	11,789,906.10	11,310,913.10	478,993.00	104%
5	Үндсэн үйл ажиллагааны зардал	9,213,831.90	12,103,284.00	11,550,191.00	553,093.00	105%
6	ҮҮА-ны нийт ашиг, алдагдал	-340,216.00	-1,869,664.60	-1,218,047.10	651,617.50	153%
7	Бусад зардал	164,421.10	55,522.40	1,697,218.20	-1,641,695.80	3%
8	Нийт зардлын дүн	9,378,252.90	12,158,806.40	13,247,409.20	-1,088,602.90	92%
9	Үндсэн ҮА-ны ашиг алдагдал	-408,880.80	-1,869,664.60	-1,215,966.10	653,698.40	154%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ /, түүний үйл ажиллагаа

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ нь эрхэм зорилгоо “Дулаан хангамж, нийтийн аж ахуйн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино. Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Зуунмод хотын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг стандартын ундны болон ахуйн хэрэглээний цэвэр ус болон дулааны эрчим хүчээр хангаж, орон сууц, сувагжуулалтын ашиглалт, үйлчилгээг сайжруулж, инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн ажиллана” гэж тодорхойлсон.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хотын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг ундны болон ахуйн хэрэглээний стандартын цэвэр усаар хангах үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудын сувагжуулалтын болон орон сууцны үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээ,
- Дулаан үйлдвэрлэл;
- Хотын инженерийн бүх төрлийн байгууламж, шугам сүлжээ, сантехникийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Компани нь үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжсэн туслах үйлдвэрлэл

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Төв аймгийн ИТХ байх бөгөөд компанийн өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавьдаг байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар “Аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулах тухай” тогтоолын дагуу байгуулагдаж, хавсралтаар байгууллагын дүрмийг баталсан байна. Байгууллагын дүрмийн 4.1.1-д заасан аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг “Компанийг өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”, 4.2.1-д “Компанийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх” гэж тус тус заасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэсэн заалттай нийцэж байна.

Байгууллагын удирдлага болон ТУЗ-ын бүрэлдэхүүнийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулж, ТУЗ нь төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч хараат 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь цалин, урамшуулал авахгүйгээр ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,139,916.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	43,167.40	102,655.70	59,488.30
Авлага	696,519.20	847,475.60	150,956.40
Урьдчилгаа	32,358.50	45,507.40	13,148.90
Бараа материал	306,262.10	518,466.70	212,204.60
Үндсэн хөрөнгө	16,091,953.90	17,801,544.50	1,709,590.60
Биет бус хөрөнгө	1,473,095.70	1,467,623.10	-5,472.60
Нийт хөрөнгийн дүн	18,643,356.80	20,783,273.00	2,139,916.20
Богино хугацаат өглөг	1,311,664.60	2,730,920.90	1,419,256.30
Урт хугацаат өглөг	8,960.90	4,461.00	-4,499.90
Өр төлбөрийн дүн	1,320,625.50	2,735,381.90	1,414,756.40
Эздийн өмч	17,322,731.30	18,047,891.10	725,159.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,643,356.80	20,783,273.00	2,139,916.20

Эх сурвалж: Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага дансны үлдэгдэл буурч, бараа материал, урьдчилж төлсөн зардал, өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 59,488.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст ХААН банкны харилцахын үлдэгдэл 46,60.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл 150,956.4 мянган төгрөгөөр өссөн нь оны эхний үлдэгдэлтэй ААНБ, иргэнээс авах авлагыг барагдуулаагүй, авлагын дүн нь 341,243.4 мянган төгрөг болж өссөн нь нөлөөлсөн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 212,204.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд нүүрс, сэлбэг хэрэгслийн материалд нөөц үүссэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,709,590.6 мянган төгрөгөөр өссөн нь Аймгийн ИТХ-ын 15-р хуралдааны 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 11 тоот тогтоол, Аймгийн Засаг даргын 3-н удаагийн захирамжаар 3, 10-р зууханд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3ш тогоо 1,600,000.0 сая төгрөгөөр худалдан авсан нь нөлөөлсөн байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,414,756.4 мянган төгрөгөөр өссөн нь нүүрс, сэлбэг хэрэгслийн нөөцөлж бэлтгэсэн, тэтгэвэрт гарсан ажилчдад өгөх 1 удаагийн тэтгэмжийг олгоогүй улмаас өглөг нэмэгдсэн байна. Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 725,159.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”, 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу Төв Чандмань ДЭХГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангуулах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 592 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,500,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,488,569.1 мянган төгрөгөөр, 11,430.9 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 83,361.1 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,520,626.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,645,829.8 мянган төгрөгийн зардал гарган 125,203.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,520,626.6 мянган төгрөг болж 20,626.6 мянган төгрөгөөр зам засвар арчлалтын ажлын орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,645,829.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 157,260.7 мянган төгрөг буюу 10,6 хувиар хэтэрсэн гүйцэтгэлтэй байна. Энэ нь үзүүлсэн үндсэн ажил үйлчилгээний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор, машин механизмын түрээсийн зардал их гарсантай холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний

төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 42,924.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны алдагдал 125,203.2 мянган төгрөг болж, 11,430.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн ашгийн төлөвлөгөөг биелүүлээгүй нь Машин механизмын түрээс, сэлбэг хэрэгсэл, шатахууны зардал өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40 хувь буюу 17,333.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

[ХАА-ын талаар нэмж бичих](#)

Commented [u1]: Орлогын төлөвлөгөө ний биелэлт ашиг алдагдал, борлуулсан бүтээгдхүүний өртгийн тооцоо гэх мэт үр дүнтэй холбоотой өгүүлбэрүүд оруулах, яагаад өглөг тэр бумаар өссөн тухай

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв Чандмань ДЭХГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Төв Чандмань ДЭХГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, урт хугацаат өр төлбөрийн асуудлыг холбогдох газраар шийдүүлж барагдуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв Чандмань ДЭХГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд, материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр 8,847,907.4 мянган төгрөгийн нийт орлогыг сонгосон.

Төв Чандмань ДЭХГ-ын материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар буюу 132,718.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 99,538.9 мянган төгрөгөөр тогтоож, аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв Чандмань ДЭХГ нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, тус хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахилгаан, халаалт дулааны зардлыг хэмнэсэн боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өсөлт, үнийн нэмэгдлээс шалтгаалан хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 183 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь бүрэн байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10,332,143.9 мянган төгрөгийн 28 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

зарлагын 1,007,738.9 мянган төгрөгийн 49 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 681,232.6 мянган төгрөгийн 3 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 58,173.3 мянган төгрөгийн 8 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна. Хуулийн хэрэгжилт 100,0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв Чандмань ДЭХГ-ын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв Чандмань ДЭХГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,452.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж, өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн Fas.audit.mn системд мэдээлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	5,452.0	3	5,452.0	100%
Албан шаардлага	1	0	1	0	100%
Зөвлөмж	1	17,798.5	1	17,798.5	100%
Нийт дүн	5	23,250.5	5	23,250.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв Чандмань ДЭХГ-ын авлагын барагдуулалтыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар дахин тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 389,444.8 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 386,899.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2,545.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

5.1 Албан шаардлага

1. Оны эхний үлдэгдэлтэй ААНБ, иргэнээс авах авлагыг барагдуулаагүй, авлагын дүн 341,243.4 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Дулааны төлбөрөөс чөлөөлсөн, хөнгөлсөн иргэдийн 45,656.4 мянган төгрөгийн орлогыг борлуулалтын хөнгөлөлт дансанд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалт болон "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Анхан шатны баримттай холбоотой асуудал**

1.1.Илрүүлэлт:

Бүрдэл хангаагүй анхан шатны баримтыг үндэслэн 2,545.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Бүрдэл хангасан анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Оны эхний үлдэгдэлтэй ААНБ, иргэнээс авах авлагыг барагдуулаагүй, авлагын дүн өссөн байна.	1	341,243.4			1	341,243.4					
Бүрдэл хангаагүй анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэсэн	1	2,545.0					1	2,545.0			
Дулаан, СӨХ-ийн төлбөрөөс чөлөөлсөн, хөнгөлсөн иргэдийн орлогыг борлуулалтын хөнгөлөлт дансанд бүртгээгүй	1	45,656.4			1	45,656.4					
Дүн	3	389,444.8	0	-	2	386,899.8	1	2,545.0	0	-	-